



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчит
хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн
үнэлгээний ажлыг зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 5, 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг зохион байгуулах зааврыг хавсралтаар баталсугай.

2. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний батлагдсан аргачлал, зааврын дагуу орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг орон нутагт зохион байгуулж, нэгдсэн тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг Нийслэлийн өмчийн харилцааны газар, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Монголбанк, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газарт харьяа байгууллагын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг батлагдсан аргачлал, зааврын дагуу Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжил, арга зүйн дор зохион байгуулж, дүнг нэгтгэн 2019 оны 3 дугаар сард багтаан тус газарт ирүүлэхийг зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн дарга Ц.Түвшинзаяа, Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Б.Гаваа нарт даалгах нь:

4.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний товхимол, гарын авлага бэлтгэн хэвлүүлэх, нийслэл, орон нутагт сургалт зохион байгуулах;

4.2. Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн, үнэлгээний ажлыг нэгдсэн аргачлалаар зохион байгуулж, дүнг 2019 оны 3 дугаар сард багтаан хүлээн авч, улсын нэгтгэлд хамруулах;

4.3. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажилтай хамтатган төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа ашиглалтгүй болон илүүдэлтэй, ашиглах хугацаа нь дууссан үндсэн хөрөнгийг газар дээр нь үзэж танилцан, худалдах,

шилжүүлэх, актлах талаар санал боловсруулж, холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх;

4.4.Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний нэгдсэн тайлан, дүнг 2019 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулах.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (Б.Гаваа)-т даалгасугай.

ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

B. Gavaa

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 08 дугаар сарын 14 ний өдрийн
367 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

Нэг. Зорилго

1.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх, орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, улсын нэгдсэн дүн гаргахад Сангийн сайдын баталсан аргачлал болон энэхүү зааврыг баримтална.

1.2. Үнэлгээний ажлын зорилго нь үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийж, үл хөдлөх хөрөнгийн талаарх мэдээллийг нэгтгэн, Засгийн газрын хэрэгцээ шаардлагыг хангахуйц тоон мэдээллийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

**Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн
үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлын
удирдлага, зохион байгуулалт**

2.1. Үнэлгээний ажлыг Сангийн сайдын тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийх бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар удирдлага, зохион байгуулалтаар хангана.

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллага удирдан зохион байгуулна.

2.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс нь төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд хамрагдах хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар болон холбогдох бусад мэдээлэл бүхий жагсаалт гаргаж, тэдгээрийг үнэлгээнд бүрэн хамруулах арга хэмжээг авч ажиллана.

2.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үнэлгээ эхлэхээс өмнө буюу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/3550 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид заасан бэлтгэлийг хангасан байна. Үүний тулд үл хөдлөх хөрөнгийн тооллого, үнэлгээний ажлын хэсэг /цаашид "байгууллагын ажлын хэсэг" гэх/-ийг тухайн байгууллагын даргын шийдвэрээр томилсон байна. Байгууллагын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өмч хамгаалах Байнгын зөвлөл, Техникийн комиссын төлөөллийг оролцуулна.

2.5. Байгууллагын ажлын хэсэг нь холбогдох баримт материалыг бүрдүүлж, тооллого, хэмжилт хийн, үнэлгээний тайлан бэлтгэх ажлыг гүйцэтгэж (батлагдсан төсөвт багтаан хараат бус үнэлгээчнээр нягтлан шалгалт хийлгэж, баталгаажуулж болно) Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газраар дүнг хянуулна.

2.6. Байгууллагын ажлын хэсэг нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө болон төрийн хөрөнгө (төсвийн хөрөнгө оруулалт)-өөр бий болсон боловч бүртгэлгүй барилга, байгууламж, олон наст ургамал, зам гүүр, далан суваг зэрэг нийтийн эзэмшлийн байгууламжийг үнэлгээнд бүрэн хамруулна.

2.7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газар нь үнэлгээний ажлын арга зүйн талаар байгууллагын ажлын хэсэгт заавар, зөвлөгөө өгч, үнэлгээний явц, чанар, үр дүнд хяналт тавьж ажиллана.

2.8. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үнэлгээний үр дүнд дараах маягт, тайлан, баримтыг бүрдүүлж, баталгаажуулан дэвтэрлэн бэлтгэнэ.

| Д/д | Бүрдүүлэх баримт материал | Баримтын хэлбэр |
|-----|---|---|
| 1 | Үнэлгээний ажлын тэмдэглэл | маягт-хуудас |
| 2 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хураангуй тайлан | Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын хавсралт № 9 |
| 3 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан | Сангийн сайдын тушаалаар баталсан Аргачлалын хавсралт №10 |
| 4 | Хуулийн этгээдийн 2018 оны ерөнхий мэдээлэл | ХҮСНЭГТ-1 |
| 5 | Эзэмшиж/ашиглаж/ байгаа газрын 2018 оны бүртгэл, үнэлгээ | ХҮСНЭГТ-2 |
| 6 | Барилга байгууламжийн 2018 оны бүртгэл, үнэлгээ | ХҮСНЭГТ-3 |
| 7 | Байгууллагын эргэлтийн бус хөрөнгө/газар, барилга, байгууламж/-ийн дахин үнэлгээний үр дүнгийн нэгтгэлийн дэлгэрэнгүй хүснэгт | Сангийн сайдын тушаалаар баталсан Аргачлалын хүснэгт №12 |
| 8 | Байршил зүйн схем зураг (барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн байгууламжийг газрын нэгж талбар дээр) | зураглал |
| 9 | Газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг (нэгж талбар тус бүрд) | хуулбар |
| 10 | Барилга, үл хөдлөх хөрөнгийн фото зураг (бүх барилга, байгууламжийн зураг) | фото |

| | | |
|----|--|----------------------------|
| 11 | Барилга тус бүрийн зохион байгуулалтын схем- (давхар бүрээр) | Барилга тус бүрд бүрдүүлнэ |
| 12 | Үнэлгээнд хамруулаагүй газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгө (нэр, үнэ) | жагсаалт |
| 13 | Газар, үл хөдлөх хөрөнгийг үнэлгээнд хамруулаагүй талаарх тайлбар | албан бичиг |

2.9. Үнэлгээний ажлын үеэр үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын байдал, бүртгэлд илэрсэн зөрчил, дутагдал, маргааны талаар дараах тайланг боловсруулна:

2.9.1. Хөрөнгийн бүртгэлд тусгаагүй үл хөдлөх хөрөнгийг төрийн (орон нутгийн) өмч мөн эсэхийг шалган, төрийн (орон нутгийн) өмч болох нь нотлогдвол “Захиргааны статистик мэдээллийн¹ “Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 2018 оны жилийн мэдээ” буюу “Маягт ТӨ-9”-ыг бүрдүүлж, тайлагнана.

2.9.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч бодитоор байхгүй үл хөдлөх хөрөнгийг мөн захиргааны статистик мэдээллийн “Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 2018 оны жилийн мэдээ” буюу Маягт-10-ыг бүрдүүлж тайлагнана.

2.9.3.Тухайн байгууллагын өмчлөл, эзэмшилд хамаарах асуудлаар маргаантай үл хөдлөх хөрөнгийг захиргааны статистик мэдээллийн “Маргаантай үндсэн хөрөнгийн 2018 оны жилийн мэдээ” буюу Маягт ТӨ-11 -ийг холбогдох зааврын дагуу бүрдүүлж тайлагнана.

Маргаантай эд хөрөнгийн асуудлаар гаргасан тайлбар, санал, дүгнэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газар судлан үзэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

2.9.4.Тухайн хуулийн этгээдэд үнэлгээний үеэр ашиглахгүй (ашиглалтын шаардлага хангахгүй, эвдэрсэн г.м), эсвэл илүүдэлтэй байгаа үндсэн хөрөнгийг “Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 2018 оны жилийн мэдээ” буюу Маягт ТӨ-12-ыг холбогдох зааврын дагуу бүрдүүлснийг газар дээр нь тулган баталгаажуулна.

2.10. Гадаад улсад байгаа төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тухайн улсад суугаа Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар үнэлгээний ажлын бэлтгэл хангах ажлын хэсгийн оролцоо, дэмжлэгтэйгээр хийж, үнэлгээний тайланг баталгаажуулан, энэ зааврын 2.8-д заасны дагуу холбогдох баримтыг бүрдүүлэн дэвтэрлэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

¹ - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан. (Эдгээр маягтыг pcsp.gov.mn цахим хуудасны “Хууль, эрх зүй” цэснээс - “төрийн өмч”-“өмч эзэмшүүлэх гэрээ” холбоосоор татаж авч болно)

2.11. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үеэр хөрөнгийг шууд данснаас хасах, актлах, устгах, шилжүүлэх, худалдахыг хориглоно. Орон нутагт ажиллах Ажлын хэсэг нь данснаас хасах, акталж устгах, шилжүүлэх, худалдах хөрөнгийн талаарх байгууллагын саналтай танилцаж, шаардлагатай баримт материалыг бүрдүүлэн холбогдох журмын дагуу шийдвэрлүүлнэ.

2.12. Монголбанк, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар нь харьяа, нэгж байгууллагын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг энэхүү зааврын дагуу Сангийн яам болон Төрийн бодлого, зохицуулалтын газрын сургалт, зөвлөгөөний дагуу зохион байгуулна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас эдгээр байгууллагын хөрөнгийн үнэлгээний ажилд хяналт тавьж ажиллана.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний дүнг тайлагнах, хүлээн авах, нэгтгэх

3.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгэн, үнэлгээний тайланг бэлтгэн баталгаажуулна. Үнэлгээний дүнг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгана.

3.2. Үнэлгээний хүснэгт, тайланг “Windows” үйлдлийн системийн Excel, Word программ дээр “Arial” фонтоор боловсруулж, тайлан маягт бүрийг байгууллагын захирал /дарга/, ерөнхий нягтлан бодогч нарын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан энэхүү зааврын 2.8-д заасны дагуу холбогдох баримт материалыг бүрдүүлэн дэвтэрлэнэ.

3.3. Үнэлгээний дэвтэрлэсэн баримтыг цахим файлын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газарт 2018 оны 12 дугаар сараас эхлэн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө.

3.4. Үнэлгээнд хамрагдаж буй хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн програм хангамжид үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг бүрэн оруулж, тус програмаас Excel программ руу өмчийн бүртгэлийн холбогдох маягтыг хөрвүүлэн ашиглана.

3.5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газрын холбогдох ажлын хэсэг үнэлгээний тайлан, баримтыг бүрдүүлбэр болон санхүүгийн тайлангийн дүнтэй тулган нягталсны үндсэн дээр хүлээн авч, “Хяналтын хуудас”, “Үнэлгээний ажлын тэмдэглэл”-ээр баталгаажуулан 1 хувийг өмчийн харилцааны байгууллагын албан хэрэгцээнд авч, 1 хувийг байгууллагад буцааж өгнө. Байгууллагын ажлын хэсэг уг баримтыг архивт хүлээлгэн өгч хадгалуулна. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл үнэлгээний баримтын 3 дахь хувийг үйлдэж болно.

3.6. Монголбанк, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар нь харьяа байгууллагын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээн авч, үнэлгээнд хамрагдсан нэгж тус бүрийн баримтыг тус бүр 1 хувь бүрдүүлэн нэгдсэн дүнгийн хамт 2019 оны 3 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хэвлэмэл болон цахим файлаар хүлээлгэн өгнө.

3.7. Нийслэлийн өмчийн харилцааны газар, Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс хүлээн авсан үнэлгээний баримт материалд үндэслэн нэгдсэн дүнг улсын нэгтгэлийн хүснэгтээр бэлтгэн гаргаж, тайлангийн хамт Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан баталгаажуулж, 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүлээлгэн өгнө.

3.8. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь нийслэл, дүүрэг дэх төрийн өмчит хуулийн этгээдээс үнэлгээний тайланг хэвлэмэл болон цахим (файл) хэлбэрээр хүлээн авч, дүнг батлагдсан нэгтгэлийн хүснэгтээр бэлтгэн, тайлангийн хамт улсын нэгтгэлд 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгтгүүлнэ.

3.9. Төрийн өмчийн хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний баримт материалыг нэгтгэн дэвтэрлэж, дэвтрийн хуудсыг дугаарлан аймаг, дүүргээр нь архивын нэгж болгон үдэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивт 2019 оны 6 дугаар сард багтаан хүлээлгэн өгнө.

3.10. Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс нь төрийн болон орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний дүнг нэгтгэн, нэгдсэн тайлан боловсруулж, 2019 оны 5 дугаар сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулна.

3.11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний нэгдсэн дүн, тайланг 2019 оны II улиралд багтаан Засгийн газарт хүргүүлнэ.

**ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАРИМТ,
МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хуулийн этгээдийн нэр:

Байршил:

Өмчлөл: Төрийн Орон нутгийн

Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр

| № | Бүрдүүлэх шаардлагатай мэдээ, тайлан | Маягт, зураглал, схем | Хуудасны тоо |
|-------------|---|--|--------------|
| 1 | Үнэлгээний ажлын тэмдэглэл | Маягт-хуудас | |
| 2 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хураангуй тайлан | Сангийн сайдын тушаалын хавсралт № 9 | |
| 3 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан | Тушаалын хавсралт №10 | |
| 4 | Хуулийн этгээдийн 2018 оны ерөнхий мэдээлэл | ХҮСНЭГТ-1 | |
| 5 | Эзэмшиж/ашиглаж/ байгаа газрын 2018 оны бүртгэл, үнэлгээ | ХҮСНЭГТ-2 | |
| 6 | Барилга байгууламжийн 2018 оны бүртгэл, үнэлгээ | ХҮСНЭГТ-3 | |
| 7 | Байгууллагын эргэлтийн бус хөрөнгө/газар, барилга, байгууламж/-ийн дахин үнэлгээний үр дүнгийн нэгтгэлийн дэлгэрэнгүй хүснэгт | Сангийн сайдын баталсан Аргачлалын хүснэгт №12 | |
| 8 | Байршил зүйн схем зураг | зураглал | |
| 9 | Газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг(нэгж талбар бүрд) | хуулбар | |
| 10 | Барилга, үл хөдлөх хөрөнгийн фото зураг (бүх барилга, байгууламжийн фото зураг) | фото | |
| 11 | Барилга тус бүрийн зохион байгуулалтын схем- (давхар бүрээр) | Схем-Барилга тус бүрд бүрдүүлнэ | |
| 12 | Үнэлгээнд хамруулаагүй газар эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгө (нэр, үнэ) | жагсаалт | |
| 13 | Газар, үл хөдлөх хөрөнгийг үнэлгээнд хамруулаагүй талаарх тайлбар | албан бичиг | |
| 14 | "Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 2018 оны жилийн мэдээ" буюу "Маягт ТӨ-9" | Маягт | |
| 15 | "Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 2018 оны жилийн мэдээ" буюу Маягт-10 | Маягт | |
| 16 | "Маргаантай үндсэн хөрөнгийн 2018 оны жилийн мэдээ" буюу Маягт ТӨ-11 | Маягт | |
| 17 | Байгууллагын 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан | хуулбар | |
| Нийт | | | хуудас |

Бүрдүүлсэн:
Байгууллагын Ажлын хэсэг:
Дарга
Гишүүд

Хянасан:
ТӨБЗГ, НӨХГ, ОНӨГ-ын Ажлын хэсэг:
нэр, гарын үсэг

ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТЭМДЭГЛЭЛ

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Ажлын хэсгийн тэмдэглэл:

Дүгнэлт

Ажлын хэсгийн дарга,
гишүүдийн нэр:

.....
.....
.....
.....
.....
(гарын үсэг)

.....
огноо

2. Нягтлан шалгалт хийсэн Үнэлгээчний тэмдэглэл

Тэмдэглэл:

Үнэлгээнд хамрагдсан газрын
нэгж талбарын тоо

Үнэлгээчний нэр:

.....
.....
(гарын үсэг)

.....
огноо

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, аймгийн Орон нутгийн өмчийн газар

Тэмдэглэл:

Ажлын хэсэг (төлөөлөгч)-ийн
дарга, гишүүдийн нэр:

.....
.....
.....
(гарын үсэг)

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН 2018 ОНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.Ерөнхий мэдээлэл

а. Нэрийн хэсэг

Байгууллагын нэр:

Регистрийн дугаар:

Улсын бүртгэлийн дугаар:

Байгуулагдсан огноо: _____ / ____ / ____ (он/сар/өдөр)

Хариуцлагын хэлбэр:

Өмчийн хэлбэр: %

Өмч эзэмшигчийн дугаар:

б. Хаягийн хэсэг

| | Нэр, агуулга |
|-------------------|--------------|
| Аймаг, нийслэл | |
| Сум, дүүрэг | |
| Оршин байгаа хаяг | |
| Утас | |
| Факс | |
| Цахим шуудан | |

в. Харьяалал

Харьяалах дээд шатны байгууллагын нэр

Харьяалах дээд шатны байгууллагын регистрийн дугаар

Салбарын тоо

Охин компанийн тоо

2. Үйл ажиллагаа, ажиллагчдын тоо

| | мд | Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл | Ажиллагчдын жилийн дундаж тоо |
|-------------------------|-----------|-----------------------------------|-------------------------------|
| Үндсэн үйл ажиллагаа | 1 | | |
| Хоёр дахь үйл ажиллагаа | 2 | | |
| | 3 | | |
| БҮГД | 10 | | |

3. Хөрөнгө, хувьцаа

Нийт хөрөнгийн хэмжээ (2018.12.31) төг.

Үүнээс: төрийн өмчийн хөрөнгийн хэмжээ төг.

(Засгийн сан/дүрмийн с

Нийт хувьцааны тоо

Үүнээс: төрийн эзэмшлийн

Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ төг.

Байгууллагын дарга/захирал /...../

Тамга гарын үсэг нэр

Ерөнхий нягтлан бодогч /...../

..... гарын үсэг нэр

20 ... оны ...-р сарын ...-ны өдөр

ХҮСНЭГТ- 1 НӨХӨХ ЗААВАР

Хүснэгтийн **нэрийн хэсэгт** төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар, байгуулагдсан огноо, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

Хариуцлагын хэлбэрийн кодыг бөглөхдөө хувьцаат компани -31, хязгаарлагдмал хариуцлагатай компани- 32 төрийн өмчит үйлдвэрийн газар- 40, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар- 50 төсөвт байгууллага- 60, бусад-80 гэсэн кодыг нөхнө.

Өмчийн хэлбэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнээс харж бичээд Төрийн өмчийн-11, Төрийн өмчийн оролцоотой-12, Төрийн өмчийн оролцоотой /хамтарсан/-13, Орон нутгийн өмчийн-31, Орон нутгийн өмчийн оролцоотой-32, Орон нутгийн өмчийн оролцоотой /хамтарсан/-33 гэсэн кодыг нөхнө. Хэрэв өмчийн хэлбэрийн код нь 12, 13, 32, 33 бол төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувийг нөхнө.

Өмч эзэмшигчийн дугаарт тухайн байгууллагын Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан өмч эзэмшлийн гэрээний дугаарыг бичнэ.

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг **төрийн өмчит** хуулийн этгээд гэнэ.

Хаягийн хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын оршин буй аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичиж, холбогдох кодыг хавсралтын дагуу нөхөх ба оршин байгаа хаяг дээр төв буюу толгой компанийн дэлгэрэнгүй хаяг, утасны дугаар, факс, цахим шуудангийн хаягийг тодорхой бичнэ.

Харьяаллын талаарх мэдээлэл хэсэгт харьяалах дээд байгууллагын нэр, регистрийн дугаар болон салбар байгууллагын тоо, охин компаний тоог нөхнө.

Харьяалах дээд байгууллага гэж аж ахуйн нэгж, байгууллагын хэтийн болон цаг үеийн бодлого, төлөвлөгөө боловсруулан удирдамж, мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг, санхүүгийн хувьд бие даасан хуулийн этгээд юм.

Охин компани гэдэг нь компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг хэлнэ.

Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.

/"Компанийн тухай" Монгол улсын хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 2, 4-р хэсэгт зааснаар/

Салбар нь толгой компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.

Эрхэлж байгаа үйл ажиллагааны хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн нэрийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын дагуу дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Тухайн байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын дийлэнх хувийг бүрдүүлэгч үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаа гэж тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагсдын тоог нөхнө. Ажиллагсдын тоог тухайн жилийн ажиллагсдын дундаж тоогоор тооцож гаргана. Хөрөнгийн талаарх мэдээлэл хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бүх хөрөнгийн нийт дүнг санхүүгийн тайланд тусгагдсанаар, түүнээс төрийн өмчийн хөрөнгийн хэмжээг, жилийн эцсийн нийт хувьцааны тоо, түүнээс төрийн өмчийн хувьцааны тоо болон нэгж хувьцааны нэрлэсэн үнийг санхүүгийн тайлангаас нөхнө.

Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ гэж тухайн хувьцааг анх гаргахдаа тогтоосон үнийг хэлнэ.

Лавлах: Хүснэгтийн талаарх лавлагааг доорх утсаар авна уу.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Утас: 265839, 62263021, 62263018, 62263016

ЭЗЭМШИЖ, АШИГЛАЖ БАЙГАА ГАЗРЫН 2018 ОНЫ БҮРТГЭЛ, ҮНЭЛГЭЭ

Хаяг: Хуулийн этгээдийн нэр.....; регистрийн дугаар.....; улсын бүртгэлийн дугаар

| Д/Д | Газрын нэр | Газрын улсын бүртгэлийн дугаар | | Газар эзэмших/ашиглах эрхийн гэрчилгээ | | | Газар эзэмшүүлэх/ашиглах шийдвэр | | | Газрыг эзэмших эрхтэй-1, ашиглах эрхтэй-2 | | Газар эзэмших/ашиглах гэрээний | | | Кадастрын зураг дахь нэгж талбарын дугаар |
|-----|------------------|--------------------------------|-------|--|-----------------|--------|----------------------------------|--------|-------|---|-------|--------------------------------|----|--|---|
| | | Дугаар | Огноо | Хугацаа | Гаргасан этгээд | Дугаар | Огноо | Дугаар | Огноо | Дугаар | Огноо | Хугацаа | | | |
| A | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | | |
| 1 | Газар-1 | | | | | | | | | | | | | | |
| 2 | Газар-2 | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | | | | | |

Байгууллагын дарга / захирал
Тамга

гарын үсэг

гарын үсгийн тайлал

Ерөнхий нягтлан бодогч

гарын үсэг

гарын үсгийн тайлал

20... оны ...-р сарын ...-ны өдөр

ХҮСНЭГТ-2 НӨХӨХ ЗААВАР

Хүснэгтийн хаягийн хэсэгт төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
А-баганад дэс дугаарыг дараалуулан нөхнө.

Б-баганад тухайн газрын нэрийг гэрчилгээнд заасан зориулалт, онцлогийг харгалзан бичиж, дугаарлана.

1-р баганад газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон газрын улсын бүртгэлийн гэрчилгээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн дугаарыг нөхнө.

2, 3, 4-р баганад газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар болон түүнийг олгосон огноо, хугацааг он/сар/өдөр гэсэн дарааллын дагуу нөхнө. Газар эзэмших эрхийн гэрчилгээ гэдэг нь "Газрын тухай" Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичиг юм.

5, 6, 7-р баганад тухайн аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан этгээд(аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)-ийн нэр, дугаар, огноог (он/сар/өдөр) нөхнө.

8-р баганад газрын эзэмшил/ашиглалтын хэлбэрээс тохирох кодыг нөхнө. Эзэмшиж байгаа бол 1, ашиглаж байгаа байгаа бол 2-гэж нөхнө.

9, 10, 11-р баганад газар эзэмших, ашиглах гэрээний дугаар, огноо, эзэмших/ашиглах хугацааг нөхнө.

12-р баганад газрын кадастрын зураг дахь нэгж талбарын дугаарыг нөхнө.

13-р баганад газрын хэмжээг буюу талбайр м.кв-аар нөхнө

14-р баганад эзэмшиж байгаа газрын байршил буюу хаягийг дэлгэрэнгүй нөхнө.

15-р баганад тухайн газрын байршлаас хамааруулан үнэлгээний зэрэглэл(бүс)-ийн дугаарыг тодруулж нөхнө. (Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол).

16-р баганад Газар ашиглалтын зориулалтыг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолд заасан аль нэг ангилалд хамруулан нөхнө.

17-р баганад тухайн газрын үнэлгээний зэрэглэл, зориулалтад харгалзах суурь үнэлгээг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын холбогдох хавсралтаас авч 1 м.кв газрын үнэлгээг төгрөгт шилжүүлсэн дүнгээр нөхнө.

18-р баганад Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээг 13 дугаар мөрөнд байгаа газрын талбайг 17 дугаар мөрөнд байгаа газрын суурь үнээр үржүүлэн газар эзэмших, ашиглах эрхийн нийт үнэлгээг гаргана. Энэ мөрөнд газрын үнэлгээ төгрөгөөр илэрхийлэгдэнэ.

19-р баганад Тухайн газарт байршдаг барилга, байгууламжийн нэрийг бичнэ.

20-р баганад Энэхүү газрын үнэлгээтэй холбоотой тайлбарыг бичнэ.

Лавлах: Хүснэгтийн талаарх лавлагааг доорх утсаар авна уу.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Утас: 265839, 62263021, 62263018, 62263016

ЭЗЭМШИЖ, АШИГЛАЖ БАЙГАА ГАЗРЫН 2018 ОНЫ БҮРТГЭЛ, ҮНЭЛГЭЭ

Хаяг: (Хуулийн этгээдийн нэр.; регистрийн дугаар.....; улсын бүртгэлийн дугаар

| Д/Д | Газрын нэр | Нийт талбай, м ² | Газрын байршил /хаяг/ Газрын бүртгэлийн дугаар | Газрын үнэлгээний зэрэглэл(бус)-ийн дугаар | Газар ашиглалтын зориулалт (Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоос) | Тухайн зэрэглэлд хамаарах суурь үнэлгээ /төг/ | Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ (төг) (18=13*17) | Эзэмшиж/ашиглаж буй газар дахь барилга, байгууламжийн нэр | Тайлбар |
|-----|------------------|--------------------------------|---|--|--|---|--|---|---------|
| A | Б | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 |
| 1 | Газар-1 | | | | | | | | |
| 2 | Газар-2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | |

Байгууллагын дарга / захирал
Тамга

гарын үсэг

гарын үсэг

гарын үсгийн тайлал

Ерөнхий нягтлан бодогч

гарын үсгийн тайлал

20... оны ...-р сарын ...-ны өдөр

